

АНГЛИ ХЭЛНИЙ ОЛОН УЛСЫН СУРГУУЛЬ ШИСТА

Internationella



Engelska Skolan

ДЭЛХИЙН ТҮВШИНГИЙН СУРАГЧИД БЭЛДДЭГ 4-9- Р АНГИ БҮХИЙ СУРГУУЛЬ

ШИСТАГИЙН АХОУС-Д ТАВТАЙ МОРИЛНО УУ

Шитстагийн АХОУС нь өөрийн гэсэн өвөрмөц онцлогтой. Бидэнтэй арай илүү танилцахын тулд сургууль дээр зохиогдох нээлттэй өдөрлөгт ирээрэй гэж та бүхнийг урья.

Бид олон улс үндэстнийг нэгтгэсэн хамт олон гэдгээрээ бахархдаг. Манай сургууль бүх сурагчдад гарал үүслээсээ үл хамааран өөрийн бүхий л чадавхийг найдвартай бөгөөд аюулгүй орчинд бүрэн дайчлан суралцах боломжийг олгож чаддаг газар юм.

Шистагийн АХОУС-г онцолж өгч буй зүйлсийн нэгээхэн том хэсэг бол олон улсын гэсэн тодотгол нь ба багш сурагчид аль аль нь олон үндэстнээс бүрддэг явдал юм. Бид сурагчиддаа чин сэтгэлээсээ хандаж, тусалдаг тийм л багаас бүрдсэн сургууль байх гэж чармайж байна. Шиста-н АХОУС -д сурагч нэг бүр ялгаагүй бүх ажилтнуудын хувьд өөрийнх нь сурагч гэсэн үг.

Нээлттэй өдөрлөгт маань хүрэлцэн ирж АХОУС- тай танилцаарай. Өөртэй тань удахгүй уулзах мөчийг хүлээж байна. Асуулт бий бол info.kista@engelska.se -аар холбогдоно уу.



МАРК ДАНЭЛ
ШИСТА АХОУС-Н ЗАХИРАЛ

Илүү ихийг : www.kista.engelska.se

Facebook: facebook.com/IESKista

Instagram: [iesk.kista](https://www.instagram.com/iesk.kista)

НЭЭЛТТЭЙ ӨДӨРЛӨГ

12- Р САРЫН 3- НЫ
БЯМБА ГАРИГТ
10:00–13:00

СУРГУУЛИЙГ ҮЗЭХ, БАГШ
НАРТАЙ УУЛЗАЖ БИДЭНТЭЙ
ТАНИЛЦАХ БОЛОМЖИЙГ
АШИГЛААРАЙ!

IES KISTA
ISAFJORDSGATAN 39
164 40 KISTA

ЭНГИЙН ГУРВАН АЛХМААР ХҮСЭЛТ ГАРГАНА:

- 1 www.kista.engelska.se хуудас руу орно
- 2 **Join Queue** буюу Дараалал болон элсэлт гэдэг дээр дарсны дараа **Join the queue here** буюу Хүсэлтээ энд гарга гэдэг дээр дарна. Та хүүхдээ төрсний дараа жилийн Хоёрдугаар сарын 1- нээс дараалалд зогсоож болно.
- 3 Маягт бөглөснөөс тань хойш элсэлт эхлэх үед бид тантай холбогддог БИД

БИД ЮУНЫ ТӨЛӨӨ АЖИЛЛАДАГ ВЭ

Англи хэлийг эзэмших

Англи хэл нь дэлхий нийтийн хэл бөгөөд бага насандаа англи ба швед хэлийг хоёуланг нь өндөр түвшинд эзэмших нь тухайн хүний цаашдын амьдралд маш том давуу тал болж өгдөг. Ямар нэг хэлийг төгс сурах шилдэг арга бол орчинд нь орох гэж бид үздэг. Тийм ч болохоор хичээлүүдийн бараг талыг төрөлх англи хэлтэй багш нар англиар заадаг.

Мэдлэг эзэмших өндөр шаардлага ба хичээл зүтгэл

Ямар гаралтайгаасаа үл хамааран хүүхэд бүр амжилтад хүрч чадна гэдэгт бид бүрэн итгэдэг. Ингэснээрээ бид сурагч нэг бүрийг амжилтад бүрэн хүрэхэд нь дэмжиж өгдөг. Бүх сурагчдаа өөртөө итгэлтэй, өөрт буй авъяас өгөгдлөө бүрэн ашиглах хүсэл эрмэлзэлтэй, хариуцлагаа ухамсарласан бие хүн болгохыг бид зорьж ажилладаг.

Аюулгүй тайван сургуулийн орчин

Дэг журам, өмнө тавигдах шаардлагыг нь тодорхой зааж өгөх нь өөртөө итгэлтэй сурагчийг бий болгодог. Бид харилцан нэгнээ хүндэлж, сурах урам зоригийг бий болгосон сургуулийг бий болгохын сацуу сурагчдаа гэсэн нэгэн сэтгэлээр хандаж, тэднийгээ цаашдын амьдралдаа амжилт ололттой байхад нь бэлддэг.

БИД ДЭЛХИЙН ХЭМЖЭЭНИЙ СУРАГЧДЫГ БЭЛТГЭНЭ.